

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГАА, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

SOCIAL GUARANTEE OF BORDER GUARD OFFICER AND WAYS TO SOLVE THEM

Х.Баясгалан

Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Хилийн албаны тэнхимийн профессор, докторант, хурандаа

Товч агуулга: Төрийн алба мэргэшсэн, тогтвортой, залгамж чанартай байж, төрийн албан хаагчийн эрх зүйн, нийгэм, эдийн засгийн болон бусад баталгаа найдвартай хангагддаг байх нь Монгол Улсын хөгжил, үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг сахиулах ¹¹төрийн тусгай албаны үндсэн чиг үүрэгт чухал нөлөө үзүүлнэ.

Монгол Улсын Их Хурлаас Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, төрийн албаны үйл ажиллагаанд дагаж мөрдсөнөөс хойш багагүй хугацаа өнгөрчээ. Шинэчлэн найруулж баталсан уг хуулийн гол үзэл баримтлал нь чадахуйн зарчимд суурилсан, шатлан дэвших тогтолцоог төрийн албанд бүрдүүлэх, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулж улмаар Монгол Улсын төрийн албыг мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай байх хууль зүйн болон практик хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэгдсэн юм. Гэвч Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь хэсэгт заасан “мэргэшсэн, тогтвортой байх” төрийн албаны зарчим төдийлөн хэрэгжихгүй байгаа нь төрийн албаны үйл ажиллагааны тасралтгүй, шуурхай, хүртээмжтэй байхад сөргөөр нөлөөлж байна.

Abstract: It is important for the civil service to be qualified, stable, and continuous, and for the legal, social, economic, and other guarantees of civil servants to be reliably provided, for the development of Mongolia, national and population security, and the basic functions of the special civil service to maintain social order. will have an effect.

Түлхүүр үгс: төрийн тусгай алба хаагч, хил хамгаалах байгууллага, нийгмийн баталгаа, цалин хөлс, тэгш байдал, ажлын ачаалал, идэвхжүүлэлт.

Key word: special civil servants, border guards, social security, wages, equality, workload and activation.

¹¹ Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “...үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг сахиулах

Оршил: Монгол Улсын төрийн албаны шинэтгэл, хөгжлийн үйл явц олон сорилтыг даван туулж, төрийн албаны чадавх, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, хүний нөөцийн удирдлагын тогтолцоо, улс төрөөс ангид мэргэшсэн, тогтвортой албыг төлөвшүүлэхэд чиглэгдэж байна. Энэ ч утгаараа хөгжлийн бүхий л цаг хугацаа, үйл явцын төвд нь мэргэшсэн, чадварлаг албан хаагч төрийн албаны гол хөдөлгөгч хүч нь байсаар ирсэн.

Дэлхий дахинд өрнөж буй цэрэг-батлан хамгаалах, аюулгүй байдлын орчин дахь эрс өөрчлөлтүүд нь бүхий л улс орнуудын нийгэм, улс төр, эдийн засагт нөлөөлж, манай улс ч энэ үйл явцаас ангид орших боломжгүй болж байна. Тиймээс хууль дээдлэн, төрийн албанд мэргэшсэн, тогтвортой, тэгш байх суурь зарчмуудыг баримтлан дэлхийн жишигт хүрсэн, өрсөлдөх чадвартай, үндэсний эв нэгдлийг хангасан төрийн тусгай албыг бэхжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дээр тоогоороо ч, хувийн жингээрээ ч хүндтэй байр суурь эзэлдэг төрийн албан хаагчдын энэхүү байр суурь сүүлийн жилүүдэд тогтворгүй, хувьсамтгай байдалд шилжих боллоо.

Үүнтэй холбоотойгоор төрийн албанд тулгамдаж байгаа олон асуудал байгаагаас зөвхөн төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, тэгш байх зарчмыг хангахад чиглэсэн асуудлыг төрийн тусгай байгууллагын нэг хил хамгаалах байгууллагын алба хаагчийн нийгмийн баталгааг хангахтай холбогдсон харилцааны хүрээнд ажлын

ачаалал, цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг хөндөж, түүнийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийг зорьж байна.

Нэг. Төрийн тусгай байгууллагын алба хаагчийн нийгмийн баталгаа, эрх зүйн үндэс.

Монгол Улсын төрөөс эрх зүйт төрийг төлөвшүүлж, төрийн албыг улс төрөөс ангид, тогтвортой, залгамж чанартай, мэргэшсэн байхад чиглэсэн бодлого боловсруулж, хуульчлан баталгаажуулсаар ирсэн.

Өнөөдөр төрийн тусгай байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчийн эрх зүйн байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад салбарын хууль тогтоомжоор зохицуулсан байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл баталгааг хуулиар тогтооно”, “Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.3.2.3-т “төрийн бодлогын залгамж чанар”-ыг хангах эрх зүй зохион байгуулалтын үндсийг бүрдүүлнэ.

Нөгөөтэйгүүр төрийн албан хаагчийн цалин хөлс нь төрийн албаны хүний нөөцийн тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх үндсэн хүчин зүйлийн нэг бөгөөд аливаа нөлөөллөөс ангид ажиллах эдийн засгийн баталгаа, хөшүүрэг нь болдог билээ. Төрийн албан хаагчдын цалинг өсгөх бодлого барьж, төсөв санхүүгийн нөхцөл байдалтай уялдуулан нэмэгдүүлэх арга

хэмжээг Засгийн газраас тухай бүр авч хэрэгжүүлж ирсэн боловч төрийн албан хаагчийн хөдөлмөрийн бүтээмж, хариуцлага ур чадвар дээр суурилсан цалингийн нэгдсэн тогтолцоог өнөөг хүртэл бүрдүүлж чадаагүй л байна.

Цэргийн алба хаагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална.

Цэргийн алба хаагчид хууль тогтоомжид заасан бусад нэмэгдэл, урамшууллыг олгож болно.¹²

Хилчин, улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа иргэн нь төрийн төлөөлөгч байж, улсын эрх ашгийн үүднээс иргэн, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавих, түүний биелэлтийг хангуулах эрхтэй.

Иргэн улсын хилд албан үүрэг гүйцэтгэх үедээ гэмт халдлагын улмаас амь насаа алдвал түүний гэр бүлд энэ хуулийн 39.8-д заасан цалингийн дунджаар тооцсон таван жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно.

Албан үүрэг гүйцэтгэж байгаад гэмтсэн, эрүүл мэнд нь хохирсон бол эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд тэтгэмж, үндсэн цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэсэн зардлыг төр хариуцна.

Улсын хил дээр алба хааж байгаа хилчний гэр бүлийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд тэднийг ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг

тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улсын төсвөөс олгоно.

Хилийн салбар, харуулд алба хааж байгаа хилчин хүнсний хангамжаар хангагдах бөгөөд хүнсний хангамжийн хэмжээг Засгийн газар тогтооно.

Хилчин, түүний гэр бүлийг ээлжийн амралтаараа /нөхөр, эхнэрийн/ нутагтаа амарвал хоёр жилд нэг удаа ирэх, очих унааны зардлыг төр хариуцна.

Улсын хилд таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн салбарт 50 хувь, суурин бус газарт байрладаг хилийн цэргийн ангид 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн цэргийн анги, агаарын цэргийн салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгоно.

Энэ хуулийн 39.2, 39.3-т заасан иргэн, хугацаат цэргийн албан хаагчийн сарын үндсэн цалинг улсын хил хамгаалах байгууллагын ахлагчийн цалинтай адилтган тооцно.

Энэ хуулийн 39.2, 39.3, 39.4, 39.5, 39.6-д заасан хөнгөлөлтийг бусад хууль тогтоомжид заасан хөнгөлөлттэй давхардуулж хэрэглэхгүй.¹³

Мерит буюу чадахуйн зарчмыг шинээр хуульчилсан нь тус зарчмыг хамгийн сайн хангасан хүнийг төрийн албанд томилох, нэгэнт өндөр

¹² Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль. УБ. 2016 он

¹³ Монгол Улсын Хилийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ УБ. 2016 он

шалгуураар томилогдсон албан хаагчийг шатлан дэвшүүлэх боломжийг бүрдүүлэх эхлэл болсон гэж болох юм. Иймд ХХБ нь тус хуулийг дагаж мөрдөх үүрэгтэй субъектийн хувиар чадахуйн зарчмыг тунхаг төдий бус, бодитой, үр дүнтэйгээр хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.¹⁴

Хоёр. Хилчдийн нийгмийн асуудал, өнөөгийн байдал

Монгол Улс нэг хүнд ногдох газар нутгийн хэмжээгээрээ дэлхийд тэргүүлдэг. Энэ өргөн уудам газар нутгийн хил хязгаарт Хил хамгаалах байгууллагын үндсэн нэгж болох хилийн анги, салбарууд байрлаж, хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ дагуу улсын хил хамгаалалтыг тасралтгүй зохион байгуулдаг өвөрмөц онцлогтой. Тиймээс ч алба хаагчид төдийгүй хилчдийн гэр бүлийн нийгмийн асуудал нэн тэргүүнд тавигдах учиртай.

Хил хамгаалах байгууллагаас 2015 онд “Хилчдийн нийгмийн хамгаалал 2024” хөтөлбөрийг боловсруулан алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого барин ажиллаж байна.

Сүүлийн арван жилд
Улаанбаатар хотод 1400 айлын
“Хилчин”, “Харуул-Алтай”
хотхонуудыг барьж, ашиглалтад
оруулан алба хаагчдыг хөнгөлөлттэй
үнээр орон сууцжуулах ажлыг хийж
гүйцэтгэсэн. Нийт хилийн анги,
салбарууд 100 хувь үүрэн телефоны
болон холбоо харилцаа зохион
байгуулах төхөөрөмж, 65 хувь нь
интернэтэд холбогдох боломж бүрдэж,
хилчид Монгол Улсын болон олон
улсын мэдээ мэдээллийг цаг алдалгүй
авах нөхцөл бүрдсэн.



¹⁴ Төрийн албаны тухай хуулийн танилцуулга

Хилийн салбаруудын 29 хувийг байнгын эрчим хүчинд холбож, 57 хувийг 5-10 кВт-ын нарны цахилгаан станцтай болгосон. Мөн алба хаагчдын 27 хувийг 10-40 м3 багтаамжтай мах хадгалах хөргүүр суурилуулан 1,5-8 тонны багтаамж бүхий хүнсний ногоо хадгалах зоорь шинээр барьж, ашиглалтад оруулсан.

Мөн “Бүсчилсэн хил хамгаалалт хөтөлбөр”-ийн хүрээнд Засгийн газрын 2017 оны 173, 174 дүгээр тогтоолууд батлагдаж, улсын хилд алба хааж байгаа хилчдийн цалинг 30-50 хүртэл хувиар нэмэгдүүлж, Цэргийн алба хаагчийн дүрэмт хувцас, хэрэглэлийн норм, хилчдийн хүнсний хангамжийн хэмжээг бүсийн онцлогоос хамаарч сайжруулах ажлыг зохион байгуулсан.

Алба хаагчдыг малжуулах зорилгоор гэрээ байгуулж, туслах аж ахуй буюу үйлдвэрлэлийн даалгавраас давсан төл малыг жил бүр алба хаагчдад олгох, Хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу Улсын хилд биечлэн таваас дээш жил алба хаасан офицер, ахлагч нарт 60 сарын үндсэн цалингаас 25-50 хүртэл хувиар тооцож, мөнгөн урамшуулал олгож байна.

“Хилчдийн нийгмийн хамгаалал 2024” хөтөлбөрт алба хаагчид төдийгүй ахмад хилчдийн талаар авах арга хэмжээг тусган 2018 онд “Ахмад хилчдийн талаар авах арга хэмжээний журам”-ыг боловсруулан батлуулж олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Мөн Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/03 дугаар тушаалыг хэрэгжүүлэх

ажлын хүрээнд Хил хамгаалах ерөнхий газрын даргын 22 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, алба хаагчдын амьжиргааны түвшин тогтоох судалгааг авч нэгтгэн Хууль, зүй дотоод хэргийн яаманд хүргүүлж, Хил хамгаалах ерөнхий газрын даргад танилцуулан тодорхой ажлуудыг төлөвлөж зохион байгуулж байна.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу улсын хилд алба хааж байгаа хилчний гэр бүлийг тэргүүн ээлжинд ажлын байраар хангах хуулийн зохицуулалттай. Ажлын байраар хангах боломжгүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлдөг. Засгийн газрын 2011 оны есдүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн алба хаагчийн гэр бүлд тэтгэмж олгох журам”-ын дагуу алслагдсан хилийн анги, салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч нарын ажил эрхлээгүй гэр бүлийн гишүүдэд улирал бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх мөнгөн тэтгэмж, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Офицер, ахлагчийн сургуулийн насны хүүхдийн боловсролыг дэмжих зорилгоор /өрхөд/ мөнгөн тусламж, тус тус олгож байна. Хилчдийн хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролыг дэмжих зорилгоор хилийн ангиудад цэцэрлэг, зарим салбаруудад гэр цэцэрлэг нээн ажиллуулж, орон нутгийн боловсролын болон эрүүл мэндийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна.


Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийг 2017 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар хилийн 0242 дугаар тусгай салбар болгож, эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг хилчид, тэдгээрийн гэр бүл, ахмад хилчдэд нэн түрүүнд, түргэн шуурхай үзүүлэн ажиллаж байна. Хилчдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2017 онд Хил хамгаалах ерөнхий газар, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгтэй хамтран нарийн мэргэжлийн эмч нарын бүлэг хилийн нийт ангид хүрч, хилчдийг 100 хувь урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Нарийн мэргэжлийн эмч нарын бүлэг 2018, 2019 онд тус бүр хилийн ангийн 50 хувьд хүрч ажиллан, өвчлөлийг бууруулах арга хэмжээ авч бие бүрэлдэхүүний өвчлөл 3-5 хувиар буурсан үр дүн гарсан.

Хил хамгаалах байгууллагын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний заавар"-ыг шинэчлэн боловсруулж, хилийн ангиудын Эрүүл мэндийн төвийг стандартын дагуу I, II, III, IV зэрэглэлтэй байхаар тусган хэрэгжүүлж эхэлсэн. Хилийн ангиудыг эмийн бус эмчилгээ, сувилал ажиллуулахад дэмжлэг үзүүлэн Аварга тосон, Хилийн рашаан, Бүрдэнэ, Хайрхан булаг зэрэг рашаан, гүүний саам, элс, шаврын улирлын чанартай сувилал ажиллуулж

алба хаагчдыг хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүй сувилах, амрах ажлуудыг зохион байгуулдаг.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд цэргийн алба хаагчдын хүнсний хангамжийн хэмжээг шинэчлэх ажлын хэсэг томилж, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн хоол судлалын албатай хамтран хилчний хүнсний хангамжийн хэмжээг өөрчлөн Засгийн газрын 174 дүгээр тогтоолоор батлуулсан. Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2018 оны А/22 дугаар тушаалаар “Хилийн цэргийн алба хаагчийн хүнсний хангалтын заавар”-ыг батлуулж, мөрдөж эхэлсэн. Хилийн салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч нар урьд нь 12 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн авдаг байсныг 25 нэр төрлөөр олгодог болсон нь хилчдийн алба хаах нөхцөлийг тодорхой хувиар сайжруулсан арга хэмжээ болсон. Хилийн анги, салбарт хүнсний хангалтыг төвлөрсөн хангалтаар сар, улирлаар хангадаг бөгөөд хилийн анги, салбар дотоод нөөц боломжоор туслах аж ахуй, газар тариалан эрхэлж, улсын хилд буюу хилийн салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч нарт Засгийн газрын тогтоолд заасны дагуу тогтоосон нормоор үнэгүй хүнс олгодог

Нийт хилчдийн



■ Нийгмийн асуудал шийдэгдсэн

■ Шийдвэрлэх шаардлагатай асуудал

Хил хамгаалах байгууллага нь хүний нөөцийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан алба хаагчдынхаа мэдлэг чадварыг дээшлүүлэх, мэргэшсэн чадварлаг алба хаагчдыг бэлтгэх зорилгоор “Хил хамгаалах байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө” гаргаж жилд дунджаар 2000 гаруй алба хаагчдыг гадаад, дотоодын урт болон богино хугацааны сургалт, семинаруудад хамруулдаг. Сургалтад хамрагдсан алба хаагчид сурсан мэдсэн зүйлээ ажил хэрэг болгох нь хамгийн чухал асуудал. Тийм учраас сургалт, дамжаа төгссөн алба хаагчдын ажлын үр дүнг тооцох асуудалд анхаарал хандуулж байна.

Дүгнэлт, санал:

Монгол Улсын Үндсэн хууль Монгол Улсын хилийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд ХХБ-ын алба хаагчдын нийгмийн асуудлыг эн тэргүүний ээлжинд анхаарах хэрэгтэй.

Монгол Улсын хувьд хил залгаа улс орнуудын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудтай ижил түвшинд

хөгжих эдийн засгийн боломж хязгаарлагдмал хэдий ч сүүлийн үед Улсын хил хамгаалалтад зайнаас удирдах орчин үеийн дэвшилтэт техник хэрэгслийг турших, шинээр хилийн отряд, застав, харуулын байр барих, авто техникийн парк шинэчлэлтийг хийх, цаашлаад хилийн цэргийн байгуулалтыг сайжруулах, шалган нэвтрүүлэх боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, цахим хилийн застав төслийг хэрэгжүүлэх зэрэг томоохон ажлуудыг бодлогын баримт бичигтээ тусган хэрэгжүүлж байгаа хэдий ч тулгамдсан дараахи асуудлууд байна.

1. Төрийн хилийн бодлогын шинэчлэл.

2. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох буюу нарийвчилсан зохицуулалт бий болгох.

3. Хүний нөөцийн асуудал /ажилд авах, томилох, сэлгэн ажиллуулах, тогтвор суурьшил, нөөц бүрдүүлэх/

4. Сургалт бэлтгэл /технологийн мэдлэгийн суурь+хил хамгаалалтын онол, сургалтыг шинэ шатанд гаргах/

5.Хилчдийн нийгмийн асуудал /ажиллаж амьдрах байр, орон сууц, цалин нэмэгдэл, сургууль, цэцэрлэг г.м/

6.Сэтгэл зүйн асуудал /амьдралын чанар буюу хилчдийн сэтгэл санааг өндөрт өргөх, стресс уур бухимдалгүй ажиллах, амьдрахад чиглэсэн олон талт ажил/

7.Ар тал хангалт /хилийн отряд, заставын барилга байгууламжийг орчин үеийн шийдлээр иж бүрэн шийдэхэд барилгын томоохон компаниудыг оролцуулах/

8.Хилийн цэргийн алба хаагчид нь суурин газраас алслагдмал хил хязгаарт алба хааж, үүрэг гүйцэтгэдэг

онцлогийг харгалзан тэдний нийгмийн асуудлыг цаг үетэй нийцүүлэн бодлогын чанартай шийдвэр гаргах шаардлагатай.

Эх сурвалжийн жагсаалт:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/
3. Монгол Улсын Хилийн тухай хууль
4. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
5. “Тэгш шан хөлс олгох тухай” олон улсын конвенци /1951/